



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/45

Булган сум

Сумын Засаг дарга, Засаг даргын
Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ,
үнэлгээ хийсэн дүнгийн тухай

Аймгийн Засаг даргын 2021 оны А/207 дугаар захирамжаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ын 11.1, 11.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажилгааны тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 1 дүгээр байр эзэлсэн Бүрэгхангай сумыг тав, 2 дугаар байр эзэлсэн Булган сумыг гурав, 3 дугаар байр эзэлсэн Сэлэнгэ, Тэшиг, Хангал, Бугат, Дашинчилэн, Рашаант сумыг тус бүр нэг сая төгрөгөөр шагнаж урамшуулсугай.

2.Шагнал урамшуулалд шаардагдах 14,000,000 (арван дөрвөн сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

3.Өргөмжлөлд шаардагдах хөрөнгийг шагналын мөнгөнөөс суутгаж олгосугай.

4.Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдалд дүгнэлт хийж, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Sugar Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

6322011197